

**САЙНЦАГААН СУМЫН ЧАДВАРТАЙ БАГШ-ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ ДЭД  
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2019.11.15

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	Сайнцагаан сумын ИТХ-ын 11-р тогтоолоор батлагдан Сумын засаг даргын А/22 тоот захирамжаар Чадвартай багш-Чанартай боловсрол сумын дэд хөтөлбөр 2018-2019 оны хичээлийн жилд хэрэгжүүлэв. <b>Зорилго:</b> “Чадвартай багш-Чанартай боловсрол” дэд хөтөлбөрийн /цаашид “хөтөлбөр” гэх/ зорилго нь багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлж, мэргэжлийн багш нарын хамтын ажиллагааг сайжруулан, 5,9,12-р ангийн сурагчдын сурах арга барилыг нэмэгдүүлж, сурлагын чанар, ахиц амжилтийг дээшлүүлэхэд оршино.			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Тамгын газрын хөрөнгө оруулалтын зардал			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар			
		Сумын Ерөнхий боловсролын сургуулиуд			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	1.Багшийн заах арга зүй, онолын мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлж, хүүхэд нэг бүрийн сурлагын чанар, ахиц амжилтыг дээшлүүлэх арга барилыг эзэмшүүлэх. 2.Сургуулиуд, мэргэжлийн багш нарын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх 3. 5,9,12-р ангийн сурагчдын сурах арга барилыг нэмэгдүүлж, сурлагын чанар, ахиц амжилтыг богино хугацаанд дээшлүүлэх			
5	Төсөв (нийт шаардагдах зардал)	10000.0 сая төгрөг			
	Зардал	Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1	5.000.000	4.822.400	100%
		Багц 2	1.700.000	1700.000	100%
		Багц 3	3.300.000	2.968.450	100%
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	<p><b>1-р зорилтын хүрээнд:</b> Багшийн заах арга зүй, онолын мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлж, хүүхэд нэг бүрийн сурлагын чанар, ахиц амжилтыг дээшлүүлэх арга барилыг эзэмшүүлэх. Хүрэх үр дүн 1: Багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлж, сурлагийн чанарт ахиц гарсан байна.</p> <p>1.Хичээлийн судалгааны арга зүй сэдэвт сургалтыг зохион байгуулж, 65 багш, сургалтын менежер , удирдлагууд оролцож, сургалтыг Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн багш удирдан зохион байгууллаа. Сургалтын онцлог нь онол практик хослуулан , багш нараар сургалтын дадлага ажил , судалгааны ажлын илтгэлүүд тавиулж , хичээл, илтгэлүүдэд хэлэлцүүлэг хийж , сайжруулах аргуудыг зааж , судалгаанд суурилсан болон сургуульд суурилсан хичээлийн судалгааны арга зүйн нэгдсэн ойлголттой болж , ур чадвар, илтгэл боловсруулах арга зүйгээ нэмэгдүүллээ. /<b>786700 төгрөг</b>/</p> <p>2. Багшийн хөгжлийг дэмжих , хөгжүүлэх багш нарын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор сумын “Залуу</p>			

	<p>багш нарын ур чадварын Анхдугаар уралдаан” онолын мэдлэг, илтгэл, заах арга зүй гэсэн 3 төрлөөр оролцож, 2-р шатанд 15 багш шалгарч, 1-р байр У.Учрал 85.73% /Мандал /, 2-р байр Г.Тогтохжаргал-79.05% /Мандал/, 3-р байр Б.Ууганцэцэг-76.89% /ГИЦС/ -тай шалгарч , Илтгэл хичээлүүд дээр сумын 84 залуу багш нар сууж туршлага судлаж, бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүллээ. Нийт 450000 төгрөг зарцууллаа. /<b>1,309300 төгрөг</b>/</p> <p>3. Залуу багш нарын хүүхэд нэг бүрийг чавдаржуулах арга барилыг сайжруулах, бусдаас суралцах, туршлага судлах боломжийг бүрдүүлэх зорилгоор Зөвлөх болон Тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй багш нарын үзүүлэх хичээлийг зохион байгууллаа. Сумын ЕБС-ын 5 сургуульд Зөвлөх зэрэгтэй багш-6, тэргүүлэх зэрэгтэй багш-26, нийт-32 багш байна.</p> <p>4. Багш нарын ажиллах таатай орчин нөхцлийг сайжруулах зорилгоор “Багшийн хөгжлийн төв”-ийг тохижуулж сургуулиуд оролцлоо. Багшийн хөгжлийн төвийг байгуулснаар багш нарт шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн хэмжээ нэмэгдэж, ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүллээ. “Шилдэг багш хөгжлийн төв”-ийн уралдаанд 1-р байрыг ЕБ-ын “Мандал” сургууль, 2-р байрыг “Цэгц билиг” сургууль эзэллээ.</p> <p>5. "Сурлагын амжилтын хяналт-шинжилгээ, үнэлгээ, суралцагчдын мэдлэг чадварыг үнэлэх арга зүй" захиалгат сургалтыг Боловсролын үнэлгээний төвөөс сургалтын менежерүүддээ авч блюпринт боловсруулах арга зүй болон даалгаврын анализ хийх арга зүйгээ нэмэгдүүллээ.</p> <p>6. Хичээлийн жилийн 3-р улирлын амралтаас эхлэн 5 сургуулийн 12-р ангийн сурагчдад 5 сургуулийн мэргэжлийн багш нар хамтран ЭЕШ-ын бэлтгэл хичээлийг явуулж нэг мэргэжлийн багш нарын харилцан туршлага судлах, хөгжих, суралцах боломж бий болсон байна. Сургууль бүр 2 судлагдахууныг хариуцан авч, ЭЕШ өгөх сурагчдыг нэгтгэн нэмэлт давтлагуудыг зохион байгууллаа.</p> <p>7. Багшийн хөгжлийн тухай хууль 2019 оны 1-р сараас эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан сургуулийн бүх багш нар багшийн хөгжлийн богино, дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх чиглэл өгч, бүх багш нар өөрийн хөгжлийн төлөвлөгөөтэй боллоо.</p> <p>8. Сурагчдад физикийн хичээлээр ЭЕШ-ын бэлтгэл хийхэд дэмжлэг үзүүлэх, физикийн багш нарын онолын мэдлэг , чадварыг нэмэгдүүлэх зорилгоор БСУГ-тай хамтран МУИС-ийн физикийн багш М.Ганбат /проф/ 3 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд 55 сурагч , 20 багш хамрагдлаа. /<b>426400 төгрөг</b>/</p> <p>9. Сургуулиудын сургалтын менежерүүд Дорнод аймгийн 3 сургуулийн хичээлийн судалгааны арга зүй,сургуулийн хөтөлбөр, менежмент, ЭЕШалгалт, чанарын үнэлгээ,сурлагын амжилтыг ахиулж байгаа туршлагыг судлан, хичээлд сууж,хамтран ажиллалаа./<b>1000000 төгрөг</b> /</p>
<p><b>2-р зорилтын хүрээнд:</b> Сургуулиуд, мэргэжлийн багш нарын хамтын</p>	<p>1.Монгол хэлний мэргэжлийн багш нар , 12-р ангийн суралцагчдын хамтарсан сонсголын хичээлийг ЭЕШ-ын</p>

<p>ажиллагааг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх Хүрэх үр дүн: Мэргэжлийн багш нарын хамтын ажиллагаа сайжирч, ур чадвар нэмэгдэнэ.</p>	<p>бэлтгэлийг сайжруулах, үр дүнг ахиулах зорилгоор хичээлийг зохион байгуулж, багш, суралцагчид харилцан туршлага судлах, багийн үйл ажиллагаагаар дамжуулан суралцагчдын сурлагын чанарыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг явууллаа.</p> <p>2. Жайка ОУБ-ын мэргэжилтэн Фүкүо Томохирог урьж сургуулийн менежмент боловруулах арга зүйн сургалтыг нийт захирал, сургалтын менежерүүдэд зохион байгуулсан. ЕБ-ын “Мандал” сургууль өөрийн сургуулийн менежментийн загварыг боловсруулж, сургуулийн хөтөлбөртэй болох зорилгоор “Сургуулийн менежмент, сургуулийн хөтөлбөрийн менежментийг боловсруулах арга зүй” сургалтыг зохион байгууллаа. БМДИ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, сургуулийн хөтөлбөрийн менежментийг боловсруулж, сургуулийн 13 судлагдахууны сургалтын хөтөлбөртэй боллоо.</p> <p>3. Сумын ТГ-ын даргын А/38 тоот тушаалаар Чадвартай багш-Чанартай боловсрол сумын дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд санаачлагатай сайн ажиллаж, элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэсэн шавь нар нь 800 оноо авсан Цэгцбилиг сургуулийн 2 багш, 500000 төгрөг, 2 сурагчдад тус бүрийг 500000 төгрөгөөр шагнаж урамшууллаа. <b>/1000,000 төгрөг/</b></p>
<p><b>3-р зорилтын хүрээнд:</b> . 5,9,12-р ангийн сурагчдын сурах арга барилыг нэмэгдүүлж, сурлагын чанар, ахиц амжилтыг богино хугацаанд дээшлүүлэх Хүрэх үр дүн: 5,9,12-р ангийн сурагчдын сурах арга барилыг нэмэгдүүлж, сурлагын чанар, ахиц амжилт дээшилнэ.</p>	<p>1. Хүн байгаль хичээлийн анги нийтийн олимпиадыг 5 дугаар ангийн 14 бүлгийн 384 сурагч оролцож, Мандал сургуулийн Э.Мөнхчулуун багштай 5а 80%, ЭДЦС-ийн Л.Мягмармядаг багштай 5г анги 76.6%, Мандал сургуулийн 5б ангийг 71,6% шалгарлч, өргөмжлөл 100000 төгрөгөөр шагнууллаа. Нийт оролцогчдын дундаж 61,14% байгаа нь аймгийн дундажийг хангалаа. <b>/533.000 төгрөг/</b></p> <p>2. ЕБСургуулиудын 9-р ангиудыг улсын шалгалтанд амжилттай бэлтгэх зорилго бүхий англи хэлний анги нийтийн Сунгааг 2 үе шаттай зохион байгуулж, 5 сургуулийн 12 бүлгийн 312 сурагч оролцлоо. Сунгааны гүйцэтгэлийн дундаж хувийг Улсын шалгалтын дундажтай харьцуулбал: ЭДЦС- 26,5% , ГИЦС-7.1%, Хүмүүнлэг - 20,9%, Цэгц билиг-4,7% , Мандал 22,2% өсөлттэй байна. <b>/435.450 төгрөг/</b></p> <p>3. 12-р ангийн математикийн хичээлийн чанарт ахиц өөрчлөлт гаргаж, анги нийтээр нь амжилттай бэлтгүүлэх зорилгоор дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан 12-р ангийн математикийн хичээлийн сорилго Цэгц билиг сургууль дээр зохион байгуулагдсан. Сумын 12-р ангид хичээл ордог 5 багш хамтран математикийн хичээлээр ЭЕШ өгөх сурагчдад нэгдсэн давтлага өгөн 6 удаа тестээр шалгалт аван анализ хийн ажиллалаа. Нэгдсэн дүн 6-н сорилын дүнгийн дундаж өнгөрсөн жилийн аймгийн дунджаас 10,3-аар дээгүүр шалгагдлаа.</p> <p>4. Сумын Засаг даргын нэрэмжит Их сорилго үйл ажиллагааг Улсын шалгалтанд бэлтгэх зорилгоор ЭЕШалгалт өгөх 98 сурагч 8 судлагдахуунаар давхардсан тоогоор 267 сурагч шалгалт өгч, шалгалтын материал шууд засагч машин ашиглан сурагчдын материалыг шууд зассаж хариуг нь тухай бүрд нь гаргаж техник технологийн шинэ дэвшил, төхөөрөмжийг анхлан авч, туршин хэрэгжүүллээ.</p>

			Их сорилын үр дүнг сургууль бүрээр харьцуулбал: ЭДЦСургууль 8 судлагдахууны дундаж 37,8, ГИЦСургууль 6 судлагдахууны дундаж 36,78, Хүмүүнлэг сургууль 5 судлагдахууны дундаж 29,14, Цэгц билиг сургууль 7 судлагдахууны дундаж 59,1% , Мандал сургууль 5 судлагдахууны дундаж 31,57% байна. Үр дүнд сурагчдын мэдлэг чадварыг бодитоор үнэлэн, ЭЕШ-ыг бөглөх дадал, цагийн хуваарилалт, мэдлэгийн түвшингээ харах , суурь судалгаа, гарааны үнэлгээтэй боллоо. /2.000.000 төгрөг/			
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		<p><b>Ололттой тал:</b> Багшийн онолын мэдлэгийн шалгалтанд 5 сургуулийн 217 багш хамрагдаж , 5,3-14,9%-ийн өсөлттэй байна.</p> <p>Сургууль бүр “Багшийн хөгжлийн төв”-ийг тохижуулж шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн хэмжээг нэмэгдүүлж, ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлээ.</p> <p>Элсэлтийн ерөнхий шалгалтанд давхардсан тоогоор 5 сургуулийн 330 хүүхэд 10 судлагдахуунаар шалгалт өгч 14.7-91.2 оноогоор өслөө.</p> <p>Математик, Нийгмийн ухааны хичээлээр 2 хүүхэд 800 оноо авч, Монгол улсын зөвлөх багш 2-оор нэмэгдэж, “Цэгцбилиг” сургууль Монгол улсын “ТОП-20” сургуулийн нэгээр шалгарлаа.</p> <p>Сургуулиудын хамтын ажиллагаа сайжирч багш, Ном хэрэглэгдэхүүний хувьд солилцож хэрэглэх, Багшийн аргазүйн нэмэгдэж, сурагчдын ажлын амжилт, сурлагийн чанарт ахиц гарсан давуу талтай. ЭЕШ-нд суралцагч бэлтгэж буй багш нар биенээсээ суралцсан харилцан туршлага судаллаа.</p> <p><b>Дутагдалтай тал:</b> Цаашид сурагчдыг анги нийтээр нь сургаж чанарын үнэлгээнд ахиц гаргах,бэлтгэх асуудал шаардлагатай байна.</p>			
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Сумын ЗДТГазрын ажлын хэсэг сургуулиудын сургалтын менежерүүдтэй хамтран удирдлагаар ханган ажиллалаа. Энэ арга хэмжээнд сургуулиудын багш нар тухайн арга хэмжээнүүдэд санаачлагатай ажиллалаа.			
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		97.8%	3	100%	93,3%	100%
10	Төсөл, хөтөлбөрийн нэгдсэн (ЗГХЭГ-ын үнэлгээ)	хэрэгжилтийн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ			
			%			

САЙНЦАГААН СУМЫН ЗДТГАЗАР